

**СТАНДАРТ, ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2021 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт түвшин /жилийн эцэс /	Хүрсэн түвшин	Хэрэгжилт тайлбар /хэрэгжээгүй бол шалтгаан/	Гүйцэтгэлийн хувь	Хэлтсийн ХШҮ 2021.11.26-ны 14 цагийн удирдлагын дүн шинжилгээний хурал
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
1.	Төсөв санхүү бүрдүүлэх	Улсын төсвөөр	Орлогын биелэлт %	58 сая	30 сая	30,5 сая	2021 оны байдлаар 30 сая төгрөгний орлого төвлөрүүлэхээс 30,5 сая төгрөгний орлого төвлөрүүлсэн байна.	100	
1.1	30 сая төгрөгийн үндсэн орлогыг төвлөрүүлэх								
2.	Орон нутгийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, экспортыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тохирлын	Улсын төсвөөр	Дэмжлэг үзүүлсэн байдлын тоо	1	2	2	Орон нутгийн бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах зорилгоор Баруун-Урт сумын 3 НБЦ, 2 талхан бүтээгдэхүүний цехэд мэргэжлийн зөвлөгөө, 1 НБЦ-д байгууллагын стандарттай болох арга зүйн зөвлөгөөг тус тус өгч, 2 гурилан бүтээгдэхүүний үйлдвэрт тохирлын үнэлгээ хийн Тохирлын гэрчилгээ нэвтрүүлсэн байна. Нутаг шим усны үйлдвэрийн тохирлын гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусаагүй байна. Аймгийн хэмжээнд тохирлын баталгаажуулалт хангалтгүй түвшинд явж байна.	100	Зөвлөгөөг өгсөн бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулан тохирлын гэрчилгээ нэвтрүүлэх

	үнэлгээний бодлого, үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлнэ.								
2.1	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгжүүдэд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.	Улсын төсвөөр	ISO 9001 стандартын дагуу зохион байгуулсан сургалтын тоо	1 байгууллага	2-оос доошгүй сургалт зохион байгуулна	2	Баруун-Урт сумын ЗДТГазар MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага, Цайрт минерал ХХК MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага, MNS ISO 14001:2016 Байгаль орчны менежментийн. Шаардлага, хэрэглэх арга зүйн заавар, Дөрвөн гэгээн эрдэнэ ХХК MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага, MNS ISO 22000:2019 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлага олон улсын стандартуудыг нэвтрүүлэхэд мэргэжлийн байгуулагатай холбож өгөх ажлыг зохион байгуулсан. Энэ хүрээнд Цайрт минерал ХХК болон Баруун-Урт сумын ЗДТГ MNS ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн байна. Байгууллагын 3 мэргэжилтэн СХЗГ-аас зохион байгуулсан ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага стандартын талаарх 3 өдрийн	100	ISO 9001 нэвтрүүлэх байгууллага аж ахуй нэгж, сумдад сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулах

							сертификаттай цахим сургалтанд хамрагдсан.		
3.	Тохирлын баталгаанд хамрагдах бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэх	Улсын төсвөөр	Нэмэгдсэн үйлчилгээний нэр төрлийн тоо	3	4	4	Сүхбаатар аймгийн “Амгалант дэнж” ОНӨААТҮГ, “Наадаан ресорт” “Ахмад”-ын амралт сувиллын газруудад тохирлын үнэлгээ хийж, тохирлын баталгаанд хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн.	100	Ахуй үйлчилгээний салбарыг тохирлын үнэлгээнд хамруулах
3.1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон үйлчилгээний байгууллагад зориулсан сургалт зохион байгуулах	1 хүний урсгал зардал	Зохион байгуулсан сургалтын тоо	3	4	4	<p>Бүтээгдэхүүн, үйлдвэрлэгчид болон үйлчилгээний байгууллагад зориулсан 2 удаагийн сургалтаар 7 сэдвээр ахлах мэргэжилтэн Ц.Өлзийжаргал, стандартын салбар сангийн мэргэжилтэн Б.Мөнхжаргал нар 50 гаруй хүнд мэдээлэл хийлээ.</p> <p>Тухайлбал:</p> <p>Удирдамж гарган Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, BEST хөтөлбөртэй хамтран сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг хамруулан 30 гаруй иргэнд чиглэл тус бүрийн холбогдох сургалтуудыг хийлээ. Манай хэлтсийн хувьд уг сургалтаар “Байгууллагын үйл ажиллагааны талаархи ерөнхий танилцуулга”, “2020, 2021 онд шинээр болон шинэчлэгдэн батлагдсан ХАА-н салбарын стандартын танилцуулга”, “Байгууллагын стандартын тухай ойлголт” “Бүтээгдэхүүн баталгаажуулалт гэж юу вэ?” зэрэг сэдвээр мэдээлэл хийж, 5 төрлийн гарын авлага тараан, сэтгэл</p>	100	

							ханамжийн судалгаа авсан. Мөн Хүнс, хөдөө аж ахуй газартай хамтран үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ эрхлэгч 20 гаруй иргэнд MNS 6843: 2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хумс заслын үйлчилгээ Ерөнхий шаардлага, MNS 5160: 2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Үс засах үйлчилгээнд тавих шаардлага. MNS 5567:2006 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага зэрэг стандартуудаар сургалт хийж, гарын авлага тараан, сэтгэл ханамжийн судалгаа авлаа.		
3.2	Засаг даргын нэрэмжит “Чанарыг эрхэмлэгч” шагнал бий болгох	Журамд зааснаар	Явцын биелэлтийн хувь	0	1	0	Намрын ногоон өдрүүд-2021 арга хэмжээний үеэр Орон нутгийн Брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулж Халзан сумын иргэн Д.Батжаргалын таанын сорс шилдэг бүтээгдэхүүнээр шалгарсан. Мөн байгууллагын “Өргөмжлөл”-ийг Түмэнцогт сумын иргэн н.Баяртуяагийн оёмол бүтээгдэхүүн, Сүхбаатар сумын талхан бүтээгдэхүүнд тус тус гардууллаа.	100	
4.	Хэмжүүр, хэмжих хэрэгслийн төрөл тоо хэмжээг нэмэгдүүлэх	Улсын төсвөөр	Нэмэгдүүлсэн хэмжих хэрэгслийн тоо	4156	2931	41	Хилийн цэргийн 0146, 0184-р ангиудын дотоодын хэрэгцээнд ашиглагдаж байгаа 41 ш электрон болон механик жингүйдийг газар дээр баталгаажуулалтад хамруулан, баталгаажуулалтанд хамрагдах хэмжих хэрэгслийн нэр, төрлийг нэмэгдүүлэн ажилласан.	100	
4.1	Хэмжүүр хэмжих хэрэгсэл ашигладаг үйлчилгээний байгууллагад зориулсан	2 хүний урсгал зардал	Зохион байгуулсан сургалтын тоо	2	3	1	ДБЭХС ТӨХК-ны Сүхбаатар аймаг дахь салбарын монтер, байцаагчийн мэргэшүүлэх сургалтанд Цахилгааны улсын шалгагч Д.Зоригтбаатар “Хэмжил зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулга” “Цахилгаан хэмжлийн төрлийн талаархи ойлголт” зэрэг сэдвээр мэдээлэл хийсэн.	45	2021 онд багтаан сургалтыг цахимаар зохион байгуул.

	сургалт зохион байгуулах								
Хэсгийн дундаж 93,1 хувь									
ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
5.	ISO 9001 стандартын шаардлагад үргэлжлэн нийцэж ажиллах	Улсын төсвөөр	Стандартын шаардлагад нийцсэн байдал	100%	100%	70%	Байгууллагын үйл ажиллагаа болон чанарын гарын авлага, дотоод мэдээлийн самбар зэргийг сайжруулан олон улсын стандартын дагуу хэрэгжүүлэн, нутагшуулж байна. Мөн хэлтэс шинэ байранд нүүж ороод MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага стандартыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.	70	Шинэ байранд орохоор хэрэгжүүлэх боломжтой
5.1	ISO 9001 стандартын дагуу дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээг зохион байгуулах	1.5 сая төгрөг	Стандартын хэрэгжилт%	0	1	1	2021 онд 2 удаа үйл ажиллагааны тайландаа стандартын дагуу дотоод аудит хийсэн.	100	ISO 9001 удирдлагын дүн тогтолцооны стандартын дагуу дотоод аудит хийж хэвших
6.	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг 80 хувь болгон дээшлүүлэх	Улсын төсвөөр	Хэрэглэгчийн сэтгэл ханамж, %	89.9%	90%	95%	Нийт 100 орчим иргэнээс сэтгэл ханамжийн судалгааг эхний хагас жил, сүүлийн хагас жилийн байдлаар цаасан болон цахим хэлбэрээр авч, дүнг нэгтгэлээ. Эхний хагас жилд 20 асуулт бүхий судалгааг хүнсний бөөний төв, худалдааны төв, супермаркет, 8-н нэрийн хүнсний дэлгүүр эрхлэгчид, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, номын сан, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, болон ерөнхий боловсролын сургуулийн	85,7	Судалгааг бусад салбарлуу нарийн гаргаж үр дүнг үйл ажиллагаанд тусгах
6.1	Хэрэглэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийнэ.								

							<p>дотуур байрны ажилчид буюу нийт 50 иргэнээс авлаа. Байгууллагын үйл ажиллагааны талаархи ерөнхий асуулт 89,2%, хэмжилзүйн чиглэлийн асуулт 92,5% стандартын чиглэлийн асуулт 91%, баталгаажуулалтын чиглэлийн асуулт 89,5% буюу дундаж оноо 90,5% тай гарсан байна.</p> <p>Сүүлийн хагас жилд 2 удаагийн танхимын сургалтын үеэр 40 орчим иргэнээс тус судалгааг авч дүнг нэгтгэн гаргасан. Судалгааны дүн 95,7%</p> <p>Мөн цахим хэлбэрээр явуулсан судалгаанд зөвхөн 6 иргэн хамрагдсан бөгөөд байгууллагын үйл ажиллагааг 75% гэж үнэлжээ.</p> <p>Нэгдсэн дүн: 85.7%</p>		
7.	Тэмдэглэлт өдрийн арга хэмжээг зохион байгуулах	Улсын төсвөөр	Төлөвлөгөөний хэрэгжилт, %	2 өдөр	3 өдөр	3 өдөр	<p>Салбарын тэмдэглэлт 4 өдрийн хүрээнд холбогдох мэдээллүүдийг орон нутгийн BBS телевиз болон цахим хаягуудаар дамжуулан сурталчиллах, видео бэлтгэн олон нийтэд хүргэн үйл ажиллагаагаа сурталчилах, Аймгийн аварга худалдагч шалгаруулах ур чадварын уралдаан зохион байгуулах, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад холбогдох стандартын дагуу зөвлөн туслах гэх мэт ажлуудыг гүйцэтгэлээ.</p> <p>Тухайлбал:</p> <p>1.Энэ жил 5-р сарын 20 Дэлхийн хэмжилзүйн өдрийг “Эрүүл мэндийн</p>	100	100
7.1	Дэлхийн хэмжил зүйн өдөр, Дэлхийн итгэмжлэлийн өдөр, Дэлхийн стандартын өдөр, Дэлхийн чанарын өдөр арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө								

	гарган хэрэгжүүлэх					<p>салбар дахь хэмжил” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд тус өдрийг тохиолдуулан орон нутгийн BBS телевизээр хэмжилзүйн талаархи 3 төрлийн богино хэмжээний видеог 2 өдрийн турш цацсан төдийгүй хэлтсийн цахим хуудсаар дамжуулан холбогдох 9 төрлийн мэдээллийг аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд сурталчилж ажиллаа. Мөн СХЗГ-аас зохион байгуулсан “Дэлхийн хэмжилзүйн өдөр”-ийн цахим сургалтанд хэлтсийн хамт олон хамрагдсан.</p> <p>2. Жил бүрийн 6-р сарын 9-ний өдрийг “Дэлхийн итгэмжлэлийн өдөр” болгон зарлаж тодорхой уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Энэ жилийн хувьд “НҮБ-н Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг Итгэмжлэлээр дэмжих нь” сэдвийн хүрээнд тэмдэглэсэн. Хэлтсийн цахим хуудсуудаар дамжуулан Итгэмжлэлтэй холбогдолтой 4 төрлийн мэдээллийг аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд сурталчиллаа.</p> <p>Мөн СХЗГ-аас зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх нь” сэдэвт онлайн семинар оролцсон.</p> <p>3. Энэ жил 10-р сарын 14 Дэлхийн стандартын өдрийг “Илүү сайхан дэлхийн төлөө хамтын алсын хараа” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд манай хэлтсийн хувьд МХГ-н лаборатори, Баруун-Урт сумын 3-р</p>		
--	--------------------	--	--	--	--	---	--	--

						<p>цэцэрлэг, “Оточ Болор” хувийн эмнэлэг, ”Энэрэлт Баясгалан” эмийн сан, Нефть-Хангамж ХХК-н ШТС, “Ханан” бялдаржуулах төв, ”Дарьганга” зочид буудал, ”Дарьганга” зочид буудлын ресторан, “Шигтгээ” хумс заслын салон, “Номин-Агуулах худалдаа”–Баруун-Урт салбар зэрэг 10 төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран богино хэмжээний стандартын видео бэлтэн орон нутгийн BBS телевиз болон цахим хэлбэрээр цацаж, иргэдэд стандартын үйл ажиллгааг сурталчилж ажиллаа.</p> <p>4. Жил бүрийн 11-р сард болдог “Дэлхийн Чанарын өдөр”-ийг тохиолдуулан 2 төрлийн ажлыг хийлээ. Тухайлбал:</p> <p>“Дэлхийн Чанарын өдөр-Үндэсний чанарын 7 хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Монгол улсад орчин цагийн худалдааны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд аймгийн болон Баруун-Урт сумын ЗДТГ, ХХААГ, ЭМГ, Сүхбаатар аймаг дахь ХАҮТ зэрэг байгууллагуудтай хамтран “Хэрэглэгчээ дээдэлж, соёлтой үйлчилье” аймгийн Аварга худалдагч шалгаруулах анхдугаар тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд 9 сумын 16 аж, ахуй нэгжийн 26 худалдагч 3 төрлөөр оролцсон.</p> <p>Орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 15 аж ахуй нэгжид сурталчилсан</p>		
--	--	--	--	--	--	---	--	--

							Мөн БСШУЯ-наас аймаг тус бүрээс хоёр цэцэрлэг сонгон MNS 6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага стандартын хэрэгжилтэнд үнэлгээ хийхтэй холбогдуулан Баруун-Урт сумын 3 болон 6-р цэцэрлэгүүдэд стандартын хэрэгжилт хэрхэн байгаад дотоод хяналт шалгалтын багуудтай нь хамтран хяналтын хуудасны дагуу үнэлгээ хийж, сайжруулах шаардлагатай 30 гаруй төрлийн ажлын жагсаалт гаргаж, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэлээ.		
Хэсгийн дундаж 89 хувь									
ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
8.	Хэмжил зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх	Улсын төсвөөр	Хэрэгжилт %	100%	100%	100%	Хэмжилзүйн тухайн хуулийн хэрэгжилтийг өдөр тутам хангаж хэрэгжүүлж байна. Хуулийн сургалтыг албан хаагчидад танилцуулсан. Өөрийн үйл ажиллагааны талаар бичлэг бэлтгэн орон нутгийн BBS телевизээр сурталчилан ажилласан.	100	Хэмжилзүйн хуулийг ард иргэдэд сурталчилах
8.1	Ажлын эталоныг бий болгох, хадгалах, ашиглах, тэдгээрийн нэгж дамжуулалтыг хангах;	2 хүний урсгал зардал	Нэгж дамжуулалт хангагдсан эталоны тоо	11	8	8	Хэлтсийн хэмжил зүйн лабораторид ашиглаж байгаа 1 фазын цахилгаан тоолуур шалгах БНХАУ-д үйлдвэрлэгдсэн DZ601 мерник, механик цусны даралтын аппарат баталгаажуулдаг НХ600В, F1 F2 зэрэг ажлын нарийн багаж хэрэгслийг улсын баталгаажуулалтанд хамруулсан.	100	
8.2	Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх	2 хүний урсгал зардал	Төлөвлөгөөний биелэлт, %	3923	2931	2930	Цахилгаан тоолуур-2159 Худалдаа үйлчилгээний жин-409 Автомашинны жин-13 Цусны даралтын аппарат-153 Шатахуун түгээгүүр-194 Усны тоолуур-2 тус тус хамруулан ажиллалаа.	99.9	

8.3	Хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх	2 хүний урсгал зардал	Төлөвлөгөөний биелэлт, %	29	20	22	Шалгалт тохируулга-22	100	
8.4	Хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулна	3 хүний урсгал зардал	Хамтарсан хяналт шалгалтын тоо	3	5	5	<p>Нефть хангамжийн салбарын инженер техникийн ажилтнуудтай хамтран хавар намрын батагаажуулалтаар 14 Шатахуун түгээх станцын 66 хошуунд хамарсан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн зөрчил дутагдлыг арилгуулан ажилласан.</p> <p>Баруун-Урт суманд үйл ажиллагаа Жаст-Ойл ШТСтанцын шатахуун шахалт, түгээлтийн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын газрын хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Т.Амартвшинтэй хамтран хяналт тавьж, иргэнээс ирсэн гомдлыг тухайн иргэнийг байлцуулан шийдвэрлэсэн. Шатахуун түгээх станцын үйл ажиллагаанд доголдол байгаагүй. Иргэний буруу олголтыг залруулан зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Цар тахалтай холбоотойгоор Аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхээс сэргийлж, МХГазар, Хууль зүйн хэлтэс , Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмэгтэй хамтран Баруун-Урт сумын хүнсний дэлгүүрүүдэд үнийн судалгаа, хүнсний нөөцийн судалгаа гаргаж, мөн тухайн дэлгүүрүүдийн өөрсдийн гараар савасан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хяналт тавьж ажилласан.</p>	100	
9.	Стандартчилал, техникийн зохицуулалт,	Улсын төсвөөр	Хэрэгжилт %	100%	100%	100%	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хэрэгжилтийг өдөр тутам хангаж	100	Хуулийн хэрэгжилтийг

	тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх						хэрэгжүүлж байна. Хуулийн сургалтыг албан хаагчидад танилцуулсан.		нарийн судлаж гаргах
9.1	Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт хийх	1 хүний урсгал зардал	Баталгаажуулсан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо	1 бүтээгдэхүүн 142 үйлчилгээ	2 бүтээгдэхүүн 80 үйлчилгээ	2 бүтээгдэхүүн 72 үйлчилгээ хагас жилээр	Баруун-Урт сумын найман гал шарга ХХК-ны 8 төрлийн гурилан бүтээгдэхүүн, Сүхбаатар аялал жуулчлал ХХК-ны Дарьганга шимийн архины үйлдвэрт баталгаажуулалт хийж тус тус тохирлын гэрчилгээ олгосон байна. Хойморьт агшуун ХХК гурилан бүтээгдэхүүн, Сүхбаатар мандал Усны үйлдвэрийн 3 төрлийн савлагаатай ус, Ганга импекс ХХК-ны Нутаг шим усны үйлдвэрийн 4 төрлийн савлагаатай усны тохирлын гэрчилгээний хугацаа дуусаагүй байна. 8 төрлийн 72 худалдаа үйлчилгээний газарт тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ нэвтрүүллээ. Мөн хугацаа нь дуусаагүй 114ш тохирлын гэрчилгээ байна Нийт хүчинтэй 186ш тохирлын гэрчилгээ мөрдөгдөж байна.	100□	2021 оны төлөвлөгдсөн худалдаа үйлчилгээний баталгаажуулалтыг бүрэн дуусгах
9.2	Экспортын бүтээгдэхүүнийг баталгаажуулах	1 хүний урсгал зардал	Экспортын гэрчилгээ олгосон бүтээгдэхүүний нэр төрлийн тоо	2	1	“Цайрт менирал” ХХК-ын 602 тн цайрын баяжмалд баталгаажуулалт хийж, экспортын 10ш гэрчилгээ олгосон. Мөн СХЗГ-н Бүтээгдэхүүн баталгаажуулалтын газраас ирсэн Экспортын бүтээгдэхүүнийг баталгаажуулалтанд хамруулах ажлыг эрчимжүүлэх тухай 2021.10.29-ны 08/664 тоот албан бичгийг Бичигт боомт дахь Гаалийн газарт хүргүүлсэн.	100		
9.3	Стандарт, техникийн зохицуулалтын улсын мэдээллийн салбар санг ажиллуулах	1 хүний урсгал зардал	Хүсэлтийн биелэлт, %	29	29	40	31 төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад 62 төрлийн 103 ш 1,547,400 төгрөгний хэвлэмэл стандартаар үйлчилж хэлтсийн Стандартын салбар сангийн журмын 01 болон 04-р хавсралтын дагуу бүртгэлжүүлсэн. 20 төрийн байгууллага болон иргэнд 50 гаруй холбогдох стандартынх нь талаар	100	

							<p>утас болон цахимаар мэдээлэл, лавлагаа өгч хэлтсийн Стандартын салбар сангийн журмын 02-р хавсралтын дагуу бүртгэлжүүлсэн.</p> <p>2020, 2021 онд шинээр батлагдсан 100 гаруй стандартыг шинээр татаж, хадгалан стандартын фондыг баяжуулан, хадгалалт ашиглалтыг хариуцан ажиллаж байна.</p>		
9.4	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад стандарт боловсруулах талаар арга зүйн зөвлөгөө өгөх	1 хүний урсгал зардал	Хүсэлтийн биелэлт, %	1	3	1	<p>“Найман Гал Шарга” ХХК-н “Дарьганга” хэвийн боовыг байгууллагын стандарттай болоход аргазүйн зөвлөгөө өглөө.</p> <p>Хэлтсийн ахлах мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуй газар, Онцгой байдлын газар, BEST хөтөлбөртэй хамтран сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нарыг хамруулан 30 гаруй иргэнд чиглэл тус бүрийн холбогдох сургалтуудыг хийлээ.</p> <p>Манай хэлтсийн хувьд уг сургалтаар “Байгууллагын стандартын тухай ойлголт” сэдвээр мэдээлэл хийсэн.</p> <p>7 бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгжээр явж Байгууллагын стандартын талаар ойлголт мэдээлэл өгч, гарын авлага тараасан.</p>	100	
9.5	Сургалт зохион байгуулах	5 хүний урсгал зардал	Зохион байгуулсан сургалтын тоо	27	23/1 2	12	<p>Цахимаар 7, танхимаар 7 буюу нийт 14 удаагийн сургалтаар 25 цэцэрлэг, 12 номын сан, 12 ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, 3 сумын ЗДТГ, МСҮТ, Баруун-Урт сумын ерөнхий боловсролын сургуулийн нэгдсэн дотуур байр, 14 хүргэлтийн хоолны газрууд, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ эрхлэгчид буюу нийт 128 төрийн болон</p>	100	

						<p>хувийн хэвшлийн байгууллагын 460 гаруй иргэнд 15 төрлийн стандартаар сургалт хийлээ.</p> <p>Тухайлбал:</p> <p><u>Цахим сургалт</u></p> <p>1. Баруун-Урт сумын 5,7,8,11-р цэцэрлэгийн эрхлэгч, багш, тогооч, ажилчдыг хамруулан 52 иргэнд MNS ISO/PAS 45005:2020 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа болон холбогдох бусад стандартаар</p> <p>2. Бүх сумдын соёлын төв, сургууль цэцэрлэгийн номын санчдыг хамруулан 18 хүнд MNS 5742:2019 Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, MNS ISO 11799:2019 Мэдээлэл ба баримтжуулалт. Архив номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавих шаардлага стандартуудаар</p> <p>3. Бүх сумдын Хүүхдийн дотуур байрны багш, ажилчдыг хамруулан 48 хүнд MNS 6781:2019 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага , MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага стандартуудаар</p> <p>4. Баруун-Урт сумын 9-р цэцэрлэг болон урд бүсийн 5 сумын цэцэрлэгүүдийн эрхлэгч, багш, ажилчдыг хамруулан 67 хүнд MNS ISO/PAS 45005:2020 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа, MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>шаардлага, MNS 6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин зэрэг стандартууд болон Хуванцар савны зохистой хэрэглээ сэдвээр</p> <p>5. Мөнххаан, Асгат, Эрдэнэцагаан зэрэг сумдын ЗДТГ-н холбогдох албан тушаалтнууд болон бусад төрийн байгууллагуудын удирдах ажилтнуудыг хамруулан 36 хүнд Байгууллагын ерөнхий танилцуулга болон MNS ISO/PAS 45005:2020 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа стандартаар</p> <p>6. Баруун-Урт сумын 2,10 болон баруун бүсийн 5 сумын цэцэрлэгийн эрхлэгч, багш, ажилчдыг хамруулан 92 хүнд MNS ISO/PAS 45005:2020 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа, MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага, MNS 6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин зэрэг стандартууд болон Хуванцар савны зохистой хэрэглээ сэдвээр</p> <p>7. Баруун-Урт сумын 6-р цэцэрлэгийн эрхлэгч, багш, ажилчдыг хамруулан 15 хүнд MNS ISO/PAS 45005:2020 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа, MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага, MNS 6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>сургалтын орчин зэрэг стандартууд болон Хуванцар савны зохистой хэрэглээ сэдвээр тус тус цахим сургалт хийлээ.</p> <p><u>Танхимын сургалт</u></p> <p>8. МСҮТ-ийн багш, ажилчдыг хамруулан 26 хүнд MNS 6541:2015 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага, Хуванцар савны зохистой хэрэглээ, MNS ISO/PAS 45005:2020 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа стандартуудаар</p> <p>9. Баруун-Урт сумын 3-р цэцэрлэгийн эрхлэгч, багш, ажилчдыг хамруулан 17 хүнд MNS 6799:2019 Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага, MNS 6558:2015 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин, MNS 5566:2020 Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх норм, MNS ISO/PAS 45005:2020 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа зэрэг стандартуудаар</p> <p>10. Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын сургуулийн Хүүхдийн нэгдсэн дотуур байрны багш, ажилчдыг хамруулан 14 хүнд MNS ISO/PAS 45005:2020 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент. COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа стандартаар</p> <p>11. МСҮТ-ийн дотуур байрны багш, дотоод чанарын баталгаажилт хариуцсан мэргэжилтэн, сургалтын менежер, захиргаа аж ахуйн менежер, жижүүр,</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>үйлчлэгч зэрэг 7 хүнд MNS 6890:2020 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага стандартаар</p> <p>12. Баруун-Урт суманд үйл ажиллагаагаа явуулж буй хоолны газруудын 12 хүнд MNS 6885:2020 Кейтеринг үйлчилгээнд тавигдах шаардлага стандартаар</p> <p>13. 10-р сарын 14 Дэлхийн стандартын өдрийг тохиолдуулан Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, BEST хөтөлбөртэй хамтран сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг хамруулан 30 гаруй хүнд холбогдох сургалтуудыг хийлээ. Манай хэлтсийн хувьд уг сургалтаар “Байгууллагын ерөнхий танилцуулга”, “2020-2021 онд шинээр болон шинэчлэн батлагдсан ХАА-н салбарын стандартууд”, “Бүтээгдэхүүн баталгаажуулалт гэж юу вэ?”, “Байгууллагын стандартын тухай ойлголт” зэрэг 4 сэдвээр мэдээлэл хийсэн.</p> <p>14. Хүнс, хөдөө аж ахуй газартай хамтран үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ эрхлэгч 20 гаруй иргэнд MNS 6843: 2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ Хумс заслын үйлчилгээ Ерөнхий шаардлага, MNS 5160: 2020 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Үс засах үйлчилгээнд тавих шаардлага. MNS 5567:2006 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Гоёлын гоо заслын үйлчилгээнд тавих шаардлага зэрэг стандартуудаар сургалт хийж, гарын авлага тараан, сэтгэл ханамжийн судалгаа авлаа.</p>	
--	--	--	--	--	--	--	--

10.	Монгол улсын засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолийг хэрэгжүүлэх	Улсын төсвөөр	Нэмэгдсэн үйлчилгээний нэр төрлийн тоо	3	4	4	Сүхбаатар аймгийн “Амгалант дэнж” ОНӨААТҮГ, “Наадаан ресорт” “Ахмад”-ын амралт сувиллын газруудад тохирлын үнэлгээ хийж, тохирлын баталгаанд хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн.	100	
10.1	Баталгаажуулалтын нэр төрлийг олшруулах	1 хүний урсгал зардал	Нэр төрлийн тоо	8	9	1	Ахмадын амралт сувилалын газарт тохирлын үнэлгээ хийн үйлчилгээний төрлийн тоог нэмэгдүүлсэн.	100	
11.	Монгол улсын засгийн газрын 2010 оны 281 дүгээр тогтоолийг хэрэгжүүлэх	Улсын төсвөөр	Сурталчилсан үйлчилгээний байгууллагын тоо	0	4	4	Баруун-Урт Сүлд хишиг ХХК, Жавхлант-Сүхбаатар ХХК, Жавхлант-Улз ХХК, Зүүн бүсийн худалдааны төвийн В-45 тоот лангуунуудыг хамруулан дүрэм, журмын танилцуулгыг хүргэн хэрэгжилтийг ханган ажилласан.	100	
11.1	Сорьцын хяналт шалгалт хийх	1 хүний урсгал зардал	Хяналт шалгалтын тоо	2	2	2	Цагаан сарын баяртай холбоотойгоор нэгдсэн удирдамжийн дагуу хэлтсийн дарга, Сорьцын хяналтын улсын байцаагч Д.Эрдэнэбат, Улсын шалгагч Э.Цогдэлгэр, Аймгийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн Я.Эрдэнэ-Очир нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг MNS 6505:2015 Мөнгөн аяга. Ерөнхий шаардлага стандартаар хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар Сүлд хишиг ХХК, Жавхлан-Сүхбаатар ХХК, Жавхлант-Улз ХХК, Зүүн бүсийн худалдааны төвийн В-45 тоот лангуунуудыг хамруулан ажилласан.	100	
Хэсгийн дундаж 99.9 хувь									
ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД									
12.	Төрийн захиргааны болон хүний нөөцийн	Улсын төсвөөр	Оролцсон байдлын %	100%	100%	100%	Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар ханган ажиллаж байна. 7 хоног бүрийн 1 дэх өдөр хуралдаж	100	

	удирдлагын манлайллаар хангах						ажилтан бүрт үүрэг өгөн манлайллаар хангаж байна.		
12.1	Орон нутгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсүүдийн үйл ажиллагааг салбарын бодлого, зорилт, Засгийн газар холбогдох дээд шатны байгууллагын шийдвэртэй уялдуулах, зохицуулах, зохион байгуулах	5 хүний урсгал зардал	100 % оролцох	6	6	6	Хэлтсийн үйл ажиллагааг салбарын бодлого журамтай уялдуулан СХЗГазар болон аймгийн ЗДТГ-аас гарч байгаа бодлого шийдвэрийн хэрэгжилтийг тухайн бүр нь хангаж өдөр тутам зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал Аймгийн ЗДТГаас 11 судалгаа, 2 журам, өдөр тутмын 14 захирамж, 1 ИТХ тогтоол, СХЗГазрын 8 судалгаа, 3 журам, 4 стандартын төсөлд санал авах, 4 шуурхай хурал, зэрэг процессийн үйл ажиллагааг шуурхай хэрэгжүүлэн ажилласан.	100	
12.2	Салбарын хүний нөөцийн удирдлагын манлайлалыг хангах, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.	Улсын төсвөөр	Хөтөлбөрийн хэрэгжилт, %	2020 оны сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал	90%	90%	2021 оны сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн биелэлт 84,1%	84.1	сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх
13.	Мэдээллийн технологийн	Улсын төсвөө	Статистик мэдээ үнэн,	4 удаа статист	4 удаа	8 удаа	Баталгаажуулалт болон хэмжилзүйн талаархи статистик мэдээг сар бүр,	100	

	бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	р	зөв гаргасан тоо	ик мэдээ гарган өгсөн			стандартын салбар сангийн статистик мэдээг улирал тутамд СХЗГ-т явуулдаг бөгөөд нийт 14 удаа статистик судалгааг гаргаж тайлагнасан.		
13.1	Статистик мэдээ гаргах								
14.	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах						Байгууллагын үйл ажиллагааг ил тод байдлын самбар, цахим хуудас, орон нутгийн телевиз, цахим сургалт гэсэн хэлбэрээр сурталчиллаа.	100	
14.1	Үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах.	Улсын төсвөөр	Мэдээллийн тоо	Жилд 29 удаа /улиралд 7-аас доошгүй удаа/.	Жилд 29 удаа /улиралд 7-аас доошгүй удаа/.		Тухайлбал: <u>Ил тод байдлын самбараар</u> Санхүүгийн болон бусад үйл ажиллагааны ил тод байдлын 3 самбараар дамжуулан иргэдэд холбогдох мэдээллүүдийг нээлттэй хүргэж байна. Байгууллагын төсөв санхүүгийн төсвийн төсөл, төсвийн хуваарь, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын санхүүгийн тайланд 2020 онд хийгдсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь ил тодын самбар болон шилэн дансанд байршуулсан төдийгүй хэлтсийн бусад самбарууд дээрхи мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар тухай бүрд нь шинэчилж байна. <u>Цахим хэлбэрээр:</u>		

						<p>Хэлтсийн 2 фейсбүүк хаяг, https://masm.gov.mn/sba/, www.masm.su.gov.mn сайт “Сүхбаатар-төсөвт байгууллага” гэсэн төрийн байгууллагуудын нэгдсэн фейсбүүк групп, Сүхбаатар аймгийн цахим группууд, орон нутгийн BBS телевизийн цахим хуудас, 3 сумын Онцгой комиссын цахим хаягууд зэрэг 10 гаруй мэдээллийн сувгуудаар дамжуулан салбарын үйл ажиллагаатай холбоотой 90 гаруй мэдээллийг түгээлээ.</p> <p>Шинээр болон шинэчилэн батлагдсан 30 гаруй стандартуудын талаархи мэдээллийг тухай бүрд нь холбогдох 10 гаруй байгууллагуудад цахимаар мэдээллийг хүргэж, стандартын захиалга авч ажилласан.</p> <p><u>Орон нутгийн BBS телевизээр:</u></p> <p>Дэлхийн Хэмжилзүйн өдрийг тохиолдуулан хэмжилзүйн талаархи 3 төрлийн богино хэмжээний видеог 2 өдрийн турш цацсан. Мөн 10-р сарын 14 Дэлхийн стандартын өдрийг “Илүү сайхан дэлхийн төлөө хамтын алсын хараа” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд манай хэлтсийн хувьд МХГ-н лаборатори, Баруун-Урт сумын 3-р цэцэрлэг, “Энэрэлт-Баясгалан” эмийн сан, “Оточ-Болор” хувийн эмнэлэг, Нефть-Хангамж ХХК-н ШТС, “Ханан” бялдаржуулах төв, ”Дарьганга” зочид буудал, ”Дарьганга” зочид буудлын ресторан, “Шигтгээ” хумс заслын салон, “Номин-Агуулах худалдаа”–Баруун-Урт</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>салбар зэрэг 10 төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран богино хэмжээний стандартын видео бэлтэн орон нутгийн телевизээр цацаж иргэдэд стандартын үйл ажиллагааг сурталчилж ажиллалаа.</p> <p>Ковид-19 цар тахалтай холбоотой хэлтсээс гаргасан видео зөвлөмжийг цацсан.</p> <p>Ковид-19 цар тахалтай холбоотой шинээр батлагдсан стандартуудын талаархи мэдээллийг урсдаг зараар дамжуулан аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд түгээсэн.</p> <p><u>Цахим сургалтаар</u></p> <p>Цахимаар 7, танхимаар 7 буюу нийт 14 удаагийн сургалтаар 25 цэцэрлэг, 12 номын сан, 12 ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, 3 сумын ЗДТГ, МСҮТ, Баруун-Урт сумын ерөнхий боловсролын сургуулийн нэгдсэн дотуур байр, 14 хүргэлтийн хоолны газрууд, сумдын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд болон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, үсчин, гоо сайхан, хумс заслын үйлчилгээ эрхлэгчид буюу нийт 128 төрийн болон хувийн байгууллагын 460 гаруй иргэнд 15 төрлийн мэдээллээр сургалт хийж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилж ажилласан.</p>		
15.	Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод,	Улсын төсвөөр	Ирүүлсэн хугацаа	Хугацаанд нь өгсөн	Хугацаанд нь	Байгууллагын хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн үндсэн зарчмуудтай нийцүүлэн зохистой удирдах	100	

	гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах				өгөх		хуулийн хугацаанд хэрэгжүүлэн цаг хугацаанд нь тайлагнаж байна.		
15.1	Байгууллагын хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн үндсэн зарчмуудтай нийцүүлэн зохистой удирдах								
16.	Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх		Удирдамжийн хэрэгжилт, %	2 удаа хийсэн	2 удаа хийн э	1 удаа хийсэн	2021 оны хагас жилийн Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж хэрэгжилтийг тайлагналаа.	100	
16.1	СХЗГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу өөрийн үйл ажиллагааны								

	гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх								
Хэсгийн дундаж 97.7 хувь									
Нийт дундаж 95хувь									

Төлөөлөгөөг хянасан:

.....
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Ерөнхийлөн захирагч

..... /...../

(гарын үсэг)

(огноо)

...2021.11.25..

Төлөөлөгөө тайлагнасан:

.....
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Шууд захирагч

..... /...../

(гарын үсэг)

(огноо)

.....